



# СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР

## СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

# 2016/6



Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг МОНСТАТ, ezStat аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ  
СТАТИСТИКИЙН ГАЗАР

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**6 сар  
2016**

Баруун-Урт сум



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
Аргачлалын тайлбар .....	4-5
Товч танилцуулга .....	6-17
Үндсэн үзүүлэлтүүд .....	18

### I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр .....	19-21
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж .....	22-23
I.3 Боловсрол .....	24
I.4 Эрүүл мэнд .....	24-26
I.5 Соёл, урлаг .....	27
I.5 Газар өмчлөл .....	28
I.6 Гэмт хэрэг .....	29-30

### II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал .....	31-32
II.2 Төрийн санхүү .....	33-34
II.3 Үнэ .....	35-36
II.4 Хөдөө аж ахуй .....	37-41
II.5 Аж үйлдвэр .....	42-44
II.6 Тээвэр холбоо .....	45
II.7 Барилга .....	45



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-VI зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0	Маш бага тоо	+, -	Зөрүү
-	Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

### IV. 15-14 нь 2015 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

### V. "Төл" нь төлөвлөгөөг, "Гүйц" нь гүйцэтгэл.

### VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Тэтгэвэр, тэтгэмж:** Уг мэдээг нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсүүд нь гарган нэгтгэж ирүүлдэг.
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
  - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
  - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Соёл, урлаг:** Соёл, урлагийн үйл ажиллагааг эрхэлдэг газрууд нь мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.
- **Газар өмчлөгч:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь сумдаас мэдээллийг авч нэгтгэн ирүүлсний дагуу мэдээллийг хүргэдэг.
- **Гэмт хэрэг:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатайгаар, болгоомжгүйгээ салах хэргийг нэгтгэн оруулсан.
- Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.



- Нийгмийн Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
- 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Мөнгө, банк, даатгал:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд үндсэн үйл ажиллагааны мэдээллийг гаргаж ирүүлдэг.
- **Төсөл:** Засгийн газрын зарим гол төслүүд болон сангуудын хөрөнгийн зээл олголт, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох хэлтэс, агентлагууд гаргаж ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь** өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.  
Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдол, тариалсан талбайн мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.  
**Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо:** гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.  
**Борлуулсан бүтээгдэхүүн нь** аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.  
**Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь** тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.
- **Тээвэр, Холбоо:** Уг үйл ажиллагааг эрхэлдэг ААН-нэгжүүд болон сумдын тамгын газрууд мэдээг нэгтгэн гаргаж ирүүлдэг.



## Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны эхний хагас жилийн байдлаар)


### I. Нийгмийн үзүүлэлт



#### I.1. Хүн ам

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 6 сард 639 хүүхэд шинээр мэндэлж, 178 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 461 болж 2015 оны мөн үеийнхээс 14.3 хувиар буюу 77-оор буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 11.0, нас баралт 3.1 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.2 пунктээр буурч, нас баралт 0.4 пунктээр өсчээ.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2012-2016 оны эхний 6 сард




#### I.2 Хөдөлмөр

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 6 дугаар сарын эцэст 1148 болсон, үүний 528 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 913 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.9 хувь буюу 132 хүнээр, 2015 оны 12 дугаар сарын эцсээс 111.3 хувь буюу 481 хүнээр тус тус өссөн байна.

Эхний 6 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст 2425 иргэн шинээр бүртгүүлсний 342 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 66.3 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 16.2 хувь нь дээд, 2.2 хувь нь тусгай дунд, 11.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 56.3 хувь нь бүрэн дунд, 10.5 хувь нь суурь, 2.7 хувь нь бага боловсролтой, 1.0 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.2.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр, 6 дугаар сарын байдлаар



Эхний 6 дугаар сарын байдлаар 347 шинэ ажлын байр бий болсны дотор хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуурын салбар 110 буюу 31.7 хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтэй байна.



### 1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 22.4 сая төгрөг буюу 0.4 хувиар буурчээ.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 363.4 сая төгрөгний шимтгэл төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82.6 сая төгрөг буюу 29.4 хувиар өссөн байна.

Нийт 7.4 мянган иргэнд 8.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосноос 5.3 мянган өндөр настанд 6.5 тэрбум төгрөг, 1.3 мянган тахир дутуу иргэнд 1.3 тэрбум төгрөг, 410 тэжээгчээ алдсан иргэнд 0.4 тэрбум, 282 иргэнд цэргийн тэтгэвэр 0.6 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний тэтгэмжийг 26 иргэнд 46.7 сая төгрөгийг тус тус бүрэн олгожээ. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 1.8 тэрбум төгрөгийг 11.7 мянган иргэнд, улсын төсвөөс 1.0 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 7.0 мянган иргэнд тус тус олгожээ.




#### I.4 Боловсрол, шинжлэх ухаан

Ерөнхий боловсролын сургуулийг 2015-2016 оны хичээлийн жилд 2003 сурагчид төгсчээ. Үүнээс бага боловсролыг 865, суурь боловсролыг 461, бүрэн дунд боловсролыг 677 сурагчид тус тус эзэмшжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт төгсөгчдын тоо 476 буюу 19.2 хувиар буурсан байна.

Нийт төгсөгчдийн 43.2 хувь нь бага, 23.0 хувь нь суурь, 33.8 хувь нь бүрэн дунд боловсролтой болсны 49.4 хувь буюу 1025 нь эмэгтэй сурагчид байна.

Зураг I.4.1 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо




#### I.5 Эрүүл мэнд

Эхний хагас жилийн байдлаар 133.8 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан бол 6.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 6.3 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэгт 49.6 мянган хүн хамрагдсан нь 13.0 хувиар тус тус өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 8.8 мянган удаа гарсны 2.5 мянга буюу 28.4 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 11.4 хувиар, алсын дуудлага 13.6 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд 634 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 639 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 58 буюу 8.4 хувиар, хүүхдийн тоо 53 буюу 7.7 хувиар тус тус буурчээ.

Зураг I.5 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо





Нялхсын эндэгдэл эхний 6 сард 15 болж, өмнөх оны мөн үеэс 3 хүүхдээр өсч, харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 болж, өмнөх оны мөн үеэс 1 хүүхдээр буурсан байна.


Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 6 сард 943 болж, өмнөх оны мөн үеэс 497 хүн буюу 111.4 хувиар өсөхөд улаан бурханаар өвчлөгчдын тоо 341 буюу 5.3 дахин, салхинцэцэгээр өвчлөгчдийн тоо 120 буюу 2.4 дахин, цусан суулга өвчлөгчдийн тоо 10 буюу 2.7 дахин, бусад өвчлөлөөр өвчлөгчдийн тоо 67 буюу 3.7 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.




### I.6 Соёл, урлаг:

**Хөгжимт жүжгийн театр:** нь 4.4 мянган үзэгчдэд 8 тоглолтоор үйлчилж 17.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдын тоо 2.5 мянга буюу 231.6 болж өссөн бөгөөд харин тоглолтын тоо 3 буюу 27.3 хувиар, орлого нь 1.0 сая төгрөг буюу 5.1 хувиар тус тус буурчээ.

Зураг I.6.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.6.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




**Музей:** 2.1 мянган үзмэрээр 0.7 мянган хүнд үйлчилж 637.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо болон үзэгчдийн тоо адил түвшинд харин үзмэрийн орлого 27.5 хувиар буюу 0.2 мянгаар буурчээ.

Зураг I.6.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.6.4 Нийт үзэгчдийн тоо






**Номын сан:** Нийт 44.7 мянган номоор 7.6 мянган уншигчдад үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс номын тоо 1.8 мянга буюу 3.8 хувиар өсч, харин уншигчдын тоо 8.7 мянга буюу 53.4 хувиар буурчээ.

Зураг I.6.5 Нийт номын тоо




Зураг I.6.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн




### I.7 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 9.2 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 8.8 мянган иргэнд 791.3 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна. Өмнөх оноос өргөдөл гаргасан иргэдийн тоо 0.8 буюу 8.0 хувиар буурчээ. Шинээр 258 иргэн өргөдөл гаргаснаас Засаг даргын шийдвэр гарсан 86 иргэнд 5.41 га газрыг тус тус олгоод байна.

Зураг I.7.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.7.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо





### I.8 Гэмт хэрэг


Эхний хагас жилд нийт 174 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 36 хүн нас барж, 93 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 2-оор өсчээ.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 344.7 сая төгрөгийн хохирол учирсны 74.8 хувийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт 175 хүн холбогдон сэжиглэгдсэний 32.6 хувь нь согтуугаар, 8.0 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ.

Нийт 279 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 39 хүн буюу 12.3 хувиар буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 33 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 84.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өссөн байна.

Зураг I.8 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, банк, даатгал


Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 93.0 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 0.8 тэрбум төгрөг буюу 0.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.0 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар тус тус буурсан байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 42.1 тэрбум төгрөг болж оны эхнээс 11.8 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 8.0 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 6 сарын эцэст 1.2 тэрбум болж өмнөх сараас 0.3 тэрбум төгрөгөөр өсч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.3 хувийг эзэлж байна.




Зураг II.1.1 Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, сарын эцэст, тэрбум төг



**Даатгал:** Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 292.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өссөн байна.

Нөхөн төлбөр 98 хүнд 29.4 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 3.1 сая, жолоочийн хариуцлагад 17.4, гэнэтийн осолд 3.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 4.7 сая, хүүхдийн гэнэтийн осолд 0.5 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг II.1.2 Даатгалын төрлөөр






## II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 6 сард 25.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөг буюу 4.5 хувиар, төсвийн зарлага санхүүжилт 25.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.0 тэрбум төгрөг буюу 13.4 хувиар тус тус өсчээ.

Аймгийн нэгдсэн төсвийн 12.6 хувийг татварын орлого, 4.9 хувийг татварын бус орлого, 0.3 хувийг хөрөнгө борлуулсны орлого, 82.2 хувийг тусламжийн орлого эзэлж байна.

Зураг.II.2.1 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг




## II.3 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2016 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувь, жилийн эцсээс 2.1 хувиар өслөө.



Зураг II.3 Хэрэглээний үнийн индекс ( өмнөх оны 12 сар=100)



Хүснэгт II.3 Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 6 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2016.VI}{2015.VI}$	$\frac{2016.VI}{2015.XII}$	$\frac{2016.VI}{2016.V}$
<b>Ерөнхий индекс</b>	<b>102.9</b>	<b>102.1</b>	<b>99.9</b>
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	99.0	106.9	98.7
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	98.3	99.8	100.0
Хувцас, бөс бараа, гутал	105.5	101.6	99.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	112.3	99.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.2	101.5	100.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	97.5	100.0	100.0
Тээвэр	95.1	100.1	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	95.4	95.4	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	121.2	109.6	109.2
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	102.7	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	105.1	102.5	100.2

**Ерөнхий индекс өмнөх жилийн эцсээс 2.1 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 6.9 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 1.6 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



## II.4 Хөдөө аж ахуй

**Мал төллөлт төл бойжилт.** Оны эхний төллөх насны 1.3 сая хээлтэгч малын 74.7 хувь буюу 996.5 мянган хээлтэгч эхний 6 сарын байдлаар төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 77.6 хувь, эм ямаа 72.5 хувь, гүү 69.3 хувь, үнээ 69.3 хувь, ингэ 35.1 хувь тус тус төллөжээ.

Гарсан төлийн 97.6 хувь болох 979.1 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 75.8 мянга буюу 1.1 пунктээр буурсан байна.

Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: унага 98.8 хувь, тугал 98.4 хувь, хурга 97.8 хувь, ишиг 96.9 хувь, ботго 96.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс бүх төрөлдөө 0.5-1.9 пунктээр буурсан байна.

Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2016 оны эхний 6 сарын байдлаар




Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2016 оны эхний 6 сарын байдлаар



**Малын онд оролт:** Том малын зүй бус хорогдол эхний 6 сард 182.9 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 170.5 мянган толгойгоор буюу 13.7 дахин өссөн байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 59, адуу 8.4 мянга, үхэр 14.9 мянга, хонь 68.8 мянга, ямаа 90.9 мянган толгой байна. Малын нийт хорогдлын 49.7 хувийг ямаа эзэлж байна.



Зураг-II.4.3 Том малын зүй бусын хорогдол, мян.тол



Аймгийн хэмжээнд хорогдсон бүх мал нь оны эхний малын 6.0 хувийг эзэлж байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон малын 0.3 хувь буюу 582 толгой мал хорогдож өмнөх оны мөн үеэс 103.5 хувиар өсчээ.

**Газар тариалан.** Эхний 6 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт төмс 61.9 га, хүнсний ногоо 30.0 га, үр тариа 9.8 мянган га, тэжээлийн ургамал 2.0 мянган га, техникийн ургамал 5.7 мянган га газарт тус тус тариалалт хийгээд байна.

Үр тариа 9.8 мянган га-д тариалснаас 9.0 мянган га-д улаан буудай, 0.8 мянган га-д овъёос, 0.1 мянган га-д арвай тариалсан байна.



## II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 12.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.8 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 9.1 тэрбум төгрөг болж 9.0 хувиар буурч, боловсруулах аж үйлдвэрийнх 307.8 сая төгрөг болж 15.1 хувь, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 3.5 тэрбум төгрөг болж 0.3 хувиар тус тус өслөө.

Оны үнээр 73.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, дулаан, түгээсэн цэвэр ус, цахилгаан, бялуу, талх, хэвийн боов, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэрчсэн гурил, цөцгий, ажлын хувцас, хөөрөгний даалин, монгол гутал, пальто, туурга, гэрийн модон тавилга зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.



## II.6 Тээвэр, холбоо


**Тээвэр:** Авто тээвэр бүхий байгууллагууд эхний 6 сард 131.6 мян.тн ачаа, давхардсан тоогоор 18.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 30.0 мян.тн буюу 29.5 хувиар өсч, харин зорчигчдын тоо 4.1 мянган хүн буюу 18.2 хувиар буурчээ.

Авто тээврийн орлого 5.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум төгрөг буюу 26.2 хувиар өссөн байна.

**Холбоо:** Холбоо ашиглалтын орлого 257.4 сая төгрөгт хүрсний 68.0 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Өмнөх оны мөн үеэс холбооны орлого 10.6 сая төгрөг буюу 4.3 хувиар, хүн амаас орох орлого 4.0 сая буюу 6.3 хувиар тус тус өссөн байна.

Телефон цэгийн тоо 571 болж, өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар буурлаа.

Зураг II.6 Холбооны үндсэн үзүүлэлт, оны үнээр сая.төг



## II.7 Барилга

Барилгын байгууллагууд эхний 6 сарын байдлаар нийт 4.3 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 1.3 тэрбум төгрөг буюу 30.6 хувь нь аймгийн барилгын байгууллага, 3.0 тэрбум төгрөг буюу 69.4 хувь нь гадны барилгын байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна.



**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний хагас жилийн  
байдлаар**

	Хэмжих нэгж	2014	2015	2016	Зөрүү
<b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>					
Төрсөн хүүхэд	хүн	645	692	639	- 53
Нялхасын эндэгдэл	хүн	14	12	15	3
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	733	781	432	- 349
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	288	446	943	497
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	181	172	174	2
Хэрэгт холбогсод	хүн	178	179	175	- 4
<b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b>					
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар					
	хувь	106.5	103.7	102.1	- 2
Иргэдийн хадгаламж	сая.төг	33 289.1	34 117.6	42 149.5	8 032
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	83 396.8	97 031.1	93 011.8	-4 019
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	25 450.7	24 130.9	25 302.9	1 172
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	26 495.8	22 311.2	25 293.4	2 982
Төлөлсөн хээлтэгч	тол	923 200	1 060 619	997	-1059 623
-Ингэ	тол	1 413	1 389	1 118	- 271
-Гүү	тол	46 086	51 995	54 560	2 565
-Үнээ	тол	50 061	58 404	57 212	-1 192
-Эм хонь	тол	480 699	554 480	536 958	-17 522
-Эм ямаа	тол	344 941	394 351	346 611	-47 740
Бойжуулсан төл	тол	922 449	1 054 894	979 092	-75 802
-Ботго	тол	1 372	1 370	1 082	- 288
-Унга	тол	45 866	51 637	53 901	2 264
-Тугал	тол	49 791	58 104	56 281	-1 823
-Хурга	тол	480 296	552 746	528 343	-24 403
-Ишиг	тол	345 124	391 037	339 485	-51 552
Том малын зүй бусын хорогдол	тол	9 802	12 452	182 993	170 541
- Тэмээ	тол	27	60	59	- 1
- Адуу	тол	242	1 128	8 383	7 255
- Үхэр	тол	2 707	710	14 864	14 154
- Хонь	тол	3 204	5 061	68 828	63 767
- Ямаа	тол	3 622	5 493	90 859	85 366
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	3 004	286	582	296
- Тэмээ	тол	1	2	-	-
- Адуу	тол	37	12	1	- 11
- Үхэр	тол	2 400	44	1	- 43
- Хонь	тол	327	167	575	408
- Ямаа	тол	239	61	5	- 56
Тариалсан талбай					
Үүнээс: Үр тариа	га	2 434.0	9 296.0	9 807.0	511
Төмс	га	74.80	71.40	61.90	- 10
Хүнсний ногоо	га	48.80	29.10	30.00	1
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	13 965.8	13 719.2	12 879.0	- 840
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	55 505.9	77 219.8	73 743.5	-3 476
Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр	сая.төг	22 786.3	10 535.7	4 339.4	-6 196
Тээврийн орлого	сая.төг	4 054.0	4 083.3	5 153.3	1 070
Тээсэн ачаа	мян.тн	73.8	101.6	131.6	30
Ачаа эргэлт	мян.тн.км	17 220.5	25 464.0	31 876.6	6 413
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	42.8	22.5	18.4	- 4
Зорчигч эргэлт	мян.хүн.км	21 245.6	13 727.0	9 793.0	-3 934
Холбооны орлого	сая.төг	262.9	246.8	257.4	11
Үүнээс: Хүн амын	сая.төг	111.0	64.0	68.0	4



## I.1 ХӨДӨЛМӨР

### I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2014		2015		2016	2016.VI 2015.VI %
	VI	XII	VI	XII	VI	
Асгат	17	33	9	3	18	200.0
Баяндэлгэр	41	46	21	8	35	166.7
Дарьганга	15	9	7	10	26	3.7*
Мөнххаан	9	16	8	4	14	175.0
Наран	17	14	7	5	10	142.9
Онгон	52	39	11	12	26	236.4
Сүхбаатар	28	33	15	10	31	206.7
Түвшинширээ	30	32	22	27	26	118.2
Түмэнцогт	33	26	8	10	27	3.3*
Уулбаян	16	12	9	1	8	88.9
Халзан	16	9	3	5	10	3.3*
Эрдэнэцагаан	41	66	38	14	47	123.7
Баруун-Урт	418	410	623	323	635	101.9
Дүн	733	745	781	432	913	116.9

### I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр					
			Дээд	Тусгай мэргэж- лийн дунд	Техник болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	18	11	1	-	5	12	-	-	-	9	7	-	2	-	-
Баяндэлгэр	35	17	2	1	5	19	4	3	1	6	12	8	3	4	2
Дарьганга	26	10	2	-	9	9	6	-	-	12	6	6	2	-	-
Мөнххаан	14	5	2	-	1	10	1	-	-	4	7	2	1	-	-
Наран	10	6	1	2	3	3	1	-	-	3	1	4	2	-	-
Онгон	26	11	5	1	4	15	1	-	-	9	10	5	2	-	-
Сүхбаатар	31	17	4	2	3	17	3	2	-	8	9	5	6	3	-
Түвшинширээ	26	13	2	3	4	12	4	1	-	10	6	7	1	2	-
Түмэнцогт	8	7	3	1	4	17	2	-	-	8	5	10	4	-	-
Уулбаян	10	4	1	-	3	4	-	-	-	5	2	1	-	-	-
Халзан	47	28	2	-	2	6	-	-	-	5	2	1	2	-	-
Эрдэнэцагаан	27	12	6	1	11	26	2	1	-	13	20	10	1	1	2
Баруун-Урт	635	266	117	9	47	364	72	18	8	134	292	132	67	8	2
Дүн	913	407	148	20	101	514	96	25	9	226	379	191	93	18	6



## I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2014		2015		2016	2016.I-VI % 2015.I-VI
	I-VI	I-XII	I-VI	I-XII	I-VI	
Асгат	31	89	11	40	42	3.8*
Баяндэлгэр	49	173	42	99	85	202.4
Дарьганга	59	42	11	38	68	6.2*
Мөнххаан	31	57	10	59	26	260.0
Наран	61	37	30	57	36	120.0
Онгон	37	95	13	73	66	5.1*
Сүхбаатар	33	134	13	59	95	7.3*
Түвшинширээ	19	100	24	85	60	250.0
Түмэнцогт	15	89	14	38	58	4.1*
Уулбаян	48	74	19	31	26	136.8
Халзан	70	74	5	47	29	5.8*
Эрдэнэцагаан	37	233	53	212	175	3.3*
Баруун-Урт	975	1 218	933	1 759	1 659	177.8
Дүн	1 465	2 415	1 178	2 597	2 425	205.9

## I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2014		2015		2016	2016.I-VI % 2015.I-VI
	I-VI	I-XII	I-VI	I-XII	I-VI	
Асгат	1	46	7	19	-	-
Баяндэлгэр	1	88	30	56	22	73.3
Дарьганга	3	25	1	17	5	5.0*
Мөнххаан	20	20	3	36	-	-
Наран	8	9	24	26	15	62.5
Онгон	5	17	3	22	2	66.7
Сүхбаатар	-	95	3	26	28	9.3*
Түвшинширээ	-	34	15	38	3	20.0
Түмэнцогт	6	29	8	13	8	100.0
Уулбаян	2	53	2	12	2	100.0
Халзан	11	53	4	30	3	75.0
Эрдэнэцагаан	2	95	15	126	32	213.3
Баруун-Урт	166	478	167	436	222	132.9
Дүн	225	1 042	282	857	342	121.3



## I.1.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаа									
	2015 VI	2016 VI	ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	Захирааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Боловсрол	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Бусад
Асгат	6	4	4	-	-	-	-	-	-	-	-	-
Баяндэлгэр	17	17	8	-	5	-	1	2	-	-	1	-
Дарьганга	-	16	7	-	-	-	6	-	3	-	-	-
Мөнххаан	-	4	4	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	8	14	10	-	-	-	1	-	-	3	-	-
Онгон	-	10	8	-	-	-	-	-	-	-	-	2
Сүхбаатар	4	16	10	-	6	-	-	-	-	-	-	-
Түвшинширээ	-	8	8	-	-	-	-	-	-	-	-	-
Түмэнцогт	5	17	5	-	2	-	5	-	-	-	3	2
Уулбаян	-	9	7	-	-	-	-	-	1	-	-	1
Халзан	4	9	9	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	22	28	7	-	-	-	1	-	-	12	-	8
Баруун-Урт	116	195	23	26	11	25	18	14	11	-	62	5
Дүн	182	347	110	26	24	25	32	16	15	15	66	18

**I.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				үүнээс: сайн дурын даатгал			
	2015.I-VI	2016.I-VI			2015.I-VI	2016.I-VI		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	94.0	93.4	112.2	120.1	10.5	6.3	12.0	190.5
Баяндэлгэр	223.9	215.4	242.8	112.7	23.6	17.6	36.4	206.8
Дарьганга	153.4	139.8	180.0	128.8	12.2	10.1	17.8	176.2
Мөнххаан	188.8	169.8	188.7	111.1	16.1	15.0	23.6	157.3
Наран	122.9	102.4	132.0	128.9	23.4	13.1	27.5	209.9
Онгон	283.1	262.2	310.9	118.6	27.3	19.9	25.3	127.1
Сүхбаатар	151.2	144.4	154.5	107.0	10.4	9.4	17.8	189.4
Түвшинширээ	151.3	134.8	182.3	135.2	15.4	10.6	32.4	305.7
Түмэнцогт	286.3	229.6	163.1	71.0	11.9	10.6	15.8	149.1
Уулбаян	215.6	162.8	170.8	104.9	18.7	12.1	18.3	151.2
Халзан	112.5	103.0	120.2	116.7	6.2	5.7	9.1	159.6
Эрдэнэцагаан	500.9	420.8	434.1	103.2	28.9	22.1	33.8	152.9
Баруун-Урт	3 187.5	3 163.7	3 257.4	103.0	76.2	64.8	93.6	144.4
Дүн	5 671.4	5 342.1	5 649.0	105.7	280.8	217.3	363.4	167.2

**I.2.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар**

Сум	Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо				Олгосон тэтгэвэр, сая.төг			
	2014.I-VI	2015.I-VI	2016.I-VI	$\frac{2016.I-VI}{2015.I-VI} \%$	2014.I-VI	2015.I-VI	2016.I-VI	$\frac{2016.I-VI}{2015.I-VI} \%$
Асгат	206	240	250	104.2	168.5	312.3	228.0	73.0
Баяндэлгэр	522	548	557	101.6	498.1	748.5	533.1	71.2
Дарьганга	299	308	317	102.9	290.3	420.9	302.0	71.8
Мөнххаан	447	462	476	103.0	346.0	629.7	441.2	70.1
Наран	170	190	192	101.1	166.2	248.7	177.0	71.2
Онгон	444	473	471	99.6	465.3	723.5	509.0	70.4
Сүхбаатар	321	342	340	99.4	298.0	451.9	314.2	69.5
Түвшинширээ	354	356	348	97.8	328.4	472.9	323.3	68.4
Түмэнцогт	335	341	336	98.5	325.7	466.9	327.6	70.2
Уулбаян	158	347	350	100.9	320.4	475.6	331.8	69.8
Халзан	668	179	186	103.9	159.1	242.6	173.8	71.6
Эрдэнэцагаан	316	708	727	102.7	667.6	1 025.8	734.3	71.6
Баруун-Урт	2 642	2 758	2 811	101.9	3 328.7	4 123.3	4 367.0	105.9
Дүн	6 882	7 252	7 361	101.5	7 362.3	10 342.6	8 762.3	84.7



## I.2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2015.I-VI		2016.I-VI	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Халамжийн сан	<b>1 Халамжийн тэтгэвэр</b>	<b>1 307</b>	<b>919.1</b>	<b>1 533</b>	<b>897.8</b>
	<b>2 Халамжийн тэтгэмж</b>	<b>669</b>	<b>174.3</b>	<b>1 261</b>	<b>116.5</b>
	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа	605	91.2	1 230	84.2
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	-	-	9	1.1
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	3.6	1	1.2
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа	53	63.6	10	12.0
	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	5	10.0	6	12.0
	Нэг удаагийн тусламж	3	3.6	-	-
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	-	-	5	6.0
	<b>3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1 006</b>	<b>358.2</b>	<b>1 155</b>	<b>386.6</b>
	байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	569	169.6	653	185.8
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	206	71.1	273	73.6
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	95	34.2	125	35.6
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	11	6.9	21	5.6
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	10	3.4	13	3.5
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	22	7.4	27	7.2
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	93	64.2	119	75.3
	<b>4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ</b>	<b>35</b>	<b>12.8</b>	<b>14</b>	<b>18.8</b>
	Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай				
	<b>5 хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж</b>	<b>3895</b>	<b>168.5</b>	<b>3 096</b>	<b>106.7</b>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	303	69.9	253	50.0	
<b>7 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал</b>	<b>4227</b>	<b>217.6</b>	<b>4 380</b>	<b>241.7</b>	
Улсын төсвөөс	1 Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1 540	340.4	2 141	319
	2 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	5 134	690.9	4 823	684.8
	3 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	14	9.0	12	10.8
	<b>ДҮН</b>	<b>18 130</b>	<b>2 970.6</b>	<b>18 668</b>	<b>2 832.7</b>

**I.3 БОЛОВСРОЛ****I.3.1 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД**

Үзүүлэлт	Шалгагдсан			Төгссөн		
	2015	2016	%	2015	2016	%
<b>Төгсөгчид / өдрөөр /</b>	2 479	2 003	80.8	2 479	2 003	80.8
Үүнээс: Бага боловсрол	906	865	95.5	906	865	95.5
Суурь боловсрол	1 052	461	43.8	1 052	461	43.8
боловсрол	521	677	129.9	521	677	129.9
<b>Төгсөгчид / орой, эчнээ /</b>	-	70	-	-	70	-
Үүнээс: Бага боловсрол	-	51	-	-	51	-
Суурь боловсрол	-	19	-	-	19	-
боловсрол	-	-	-	-	-	-
<b>Төгсөгчид / Бүгд /</b>	2 479	2 073	83.6	2 479	2 073	83.6
Үүнээс: Бага боловсрол	906	916	101.1	906	916	101.1
Суурь боловсрол	1 052	480	45.6	1 052	480	45.6
боловсрол	521	677	129.9	521	677	129.9

**I.4 ЭРҮҮЛ МЭНД****I.4.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2015.I-VI	2016.I-VI	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	134.4	133.8	-0.6	99.6
2. Ор хоног	мян.хүн	52.5	54.7	2.2	104.2
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	43.9	49.6	5.7	113.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	6.4	6.8	0.4	106.3
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	7.9	8.8	0.9	111.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.2	2.5	0.3	113.6
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	255	515	260	202.0
7. Нийт нас баралт	хүн	154	178	24	115.6
8. Амаржсан эх	хүн	692	634	-58	91.6
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	692	639	-53	92.3
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	12	15	3	125.0
10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд	хүн	3	2	-1	66.7



## I.4.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	-	-
Баяндэлгэр	2	2	-	2
Дарьганга	4	4	2	-
Мөнххаан	7	7	2	-
Наран	2	2	-	-
Онгон	2	2	4	-
Сүхбаатар	1	1	-	-
Түвшинширээ	1	1	-	-
Түмэнцогт	-	-	-	-
Уулбаян	3	2	2	-
Халзан	-	-	-	-
Эрдэнэцагаан	9	8	-	-
Баруун-Урт	603	610	5	-
Дүн	634	639	15	2

## I.4.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, сумаар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2015.I-VI	2016.I-VI	Өсөлт	
				тоо	хувь
Вируст гепатит	хүн	9	5	-4	55.6
Цусан суулга	хүн	6	16	10	2.7*
Улаан бурхан	хүн	80	421	341	5.3*
Салхинцэцэг	хүн	86	206	120	239.5
Сүрьеэ	хүн	49	37	-12	75.5
Тэмбүү	хүн	75	80	5	106.7
Заг	хүн	67	32	-35	47.8
Трихоминиаз	хүн	49	54	5	110.2
Бусад	хүн	25	92	67	3.7*
Бүгд	хүн	446	943	497	211.4



## I.4.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

Сум	Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд			Вируст гепатит	Цусан суулга	Улаан бурхан	Салхинцэцэг	Сүрьеэ	Тэмбүү	Заг	Трихоминиаз
	2015.I-VI	2016.I-VI	1000 хүн тутамд								
Асгат	12	8	4.7	-	-	-	1	4	1	-	2
Баяндэлгэр	58	13	2.7	-	-	3	-	3	2	2	3
Дарьганга	3	7	2.3	-	-	2	2	1	1	-	1
